



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 338,886,358.00 (гурван зуун гучин найман сая найман зуун наян зургаан мянга гурван зуун тавин найман) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд, Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга М.Баяраа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ

АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001447

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 2 дугаар сарын 21-ны өдрийн
67 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН, БАГАНУУР ДҮҮРГИЙН
ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

Д/д	Хөрөнгийн нэр	Хаяг	Үзүүлэлт	Барилга	Бүгд дүн /төгрөг/
1	Эрүүлжүүлэх байрны барилга	Улаанбаатар, Багануур дүүрэг, 1 хороо	Тэнхлэгээрээ 12.0м х21.0м хэмжээтэй, 1 давхар	Үндсэн хийц	285,620,970.00
			Гадна дулааны шугам 108м Гадна цэвэр усны шугам 105м Гадна бохирын шугам 26м	Гадна инженерийн шугам	46,657,388.00
			Гадна цахилгааны кабель-56 м	гадна цахилгааны шугам 380 в	6,608,000.00
Нийт дүн					338,886,358.00 (гурван зуун гучин найман сая найман зуун наян зургаан мянга гурван зуун тавин найман)